

**АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН
ШАЛГАХ АЛБАНЫ ЧАДАМЖИД СУУРИЛСАН
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

1. Үнэлгээний зорилго

Байгууллагын:

- Хүний нөөц
- Техник, тоног төхөөрөмж
- Удирдлага, зохион байгуулалт
- Мэдээлэл технологи
- Үйл ажиллагааны бэлэн байдал гэсэн үндсэн чадамжууд дээр тулгуурлан эрсдэлийг тодорхойлно.

2. Байгууллагын бүтэц (одоогийн байдал)

Нийт: Бүрэлдэхүүн 10 албан хаагч

- Ерөнхий шинжлэн шалгагч (дарга)
- Ахлах шинжлэн шалгагч
- Нислэгийн шинжлэн шалгагч
- Нислэг хөдөлгөөний шинжлэн шалгагч
- Техникийн шинжлэн шалгагч
- Техникийн шинжлэн шалгагч (Нислэгийн бичлэг)
- Гадаад харилцаа хуулийн мэргэжилтэн
- Бүртгэл, судалгааны мэргэжилтэн
- Санхүү, нягтлан бодогч
- Бичиг хэрэг, туслах ажилтан

Онцлог: Олон үүрэг давхар гүйцэтгэх шаардлагатай жижиг бүтэц

3. Чадамжид суурилсан эрсдэлийн ангилал

3.1 Хүний нөөцийн чадамж

Эрсдэл	Шалтгаан	Үр дагавар	Түвшин
Шинжлэн шалгагч, ажилтан хүрэлцэхгүй	10 орон тоо бага. Үүнээс Шинжлэн шалгагч 6.	Шуурхай хариу арга хэмжээ авах, Олон ослыг зэрэг шалгах боломжгүй	Өндөр
Мэргэшлийн хомсдол	Нарийн мэргэшүүлсэн мэргэжилтэн	Шинжилгээ дутуу, алдаа	Өндөр
Давхар үүрэг гүйцэтгэл	Олон үүрэг рольтой	Ядаргаа, стресс, алдаа, анхаарал саринах	Өндөр
Туршлага алдагдах	Халаа сэлгээ	Чадамж буурах	Дунд -

			Өндөр
Залуу Шинжээчдын нөөцийн хомсдол	Цалин хангамж муу	Шинжээчээр ажиллах сонирхолгүй	Өндөр

3.2 Хууль эрх зүйн чадамж

Эрсдэл	Шалтгаан	Үр дагавар	Түвшин
Хуулийн зүйл, заалтуудын зохицуулалт хангалтгүй	Бие даасан байдлыг бүрэн хангаагүй	Чадамж дорой	Дунд
Үйл ажиллагааны дүрэм, журам сул	Зохицуулалт дутмаг	Алдаа	Өндөр
Стандарт дутуу	Системгүй	Үр дүн буурах	Өндөр

3.3 Барилга байгууламж

Эрсдэл	Шалтгаан	Үр дагавар	Түвшин
Оффисийн байргүй, нэг ажилтны ажлын байрны стандарт хангагдахгүй	Ажлын орчин муу	Бүтээлч ажиллагаа буурах	Маш өндөр
Тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалтын агуулахгүй	Хадгалалт, Хамгаалалт муу	Эд зүйлс багтахгүй	Өндөр
Ослоос үлдсэн овор ихтэй нотлох баримтуудыг байрлуулж шинжилгээ хийх боломжгүй, лабораторигүй	Шинжилгээ, судалгааны ажил сул	Дүгнэлт буруу гарах	Өндөр

3.4 Техник, тоног төхөөрөмж

Эрсдэл	Шалтгаан	Үр дагавар	Түвшин
FDR/CVR унших чадвар хязгаарлагдмал	Тоног төхөөрөмж дутмаг	Гадаад хамаарал	Өндөр
Лабораторид шинжилгээ, судалгаа хийх боломжгүй	Дотоод нөөцгүй	Шинжилгээ удаашрах	Өндөр
Тоноглол байрлуулах байр, талбай дутмаг	Хувийн хамгаалах хэрэгсэл, хамгаалалт	Аюулгүй байдал буурах	Дунд

3.5 Үйл ажиллагааны чадамж

Эрсдэл	Шалтгаан	Үр дагавар	Түвшин
Олон осол зэрэг гарах	Нөөц бага	Шалгалтын шат дараалсан үйлдлийн	Маш өндөр

		саатал	
Алслагдсан бүсэд хүрэх	Логистик сул	Хугацаа, Мэдээлэл алдагдах	Өндөр
24/7 бэлэн байдал сул	Хүний нөөц хүрэлцэхгүй	Шуурхай байдал алдагдах	Өндөр

3.6 Удирдлага, зохион байгуулалт

Эрсдэл	Шалтгаан	Үр дагавар	Түвшин
Хэт төвлөрсөн шийдвэр	Даргад төвлөрөх	Саатал	Дунд
Стандарт мөрдөлт сул	SOP дутмаг	Алдаа	Өндөр
Чанарын хяналт сул	QA/QC системгүй	Тайлангийн чанар буурах	Өндөр

3.7 Мэдээлэл, дата чадамж

Эрсдэл	Шалтгаан	Үр дагавар	Түвшин
Өгөгдөл алдагдах	Санамж, Нөөцлөлт сул	Чухал нотлох баримт устгах	Маш өндөр
Кибер эрсдэл	Хамгаалалт сул	Мэдээлэл задрах, алдагдах	Өндөр
Анализын программ дутмаг	Программ хангамж хомс	Шинжилгээ сул	Дунд-Өндөр

3.8 Санхүү, нөөц

Эрсдэл	Шалтгаан	Үр дагавар	Түвшин
Төсөв хязгаарлагдмал	Улсын санхүүжилт	Чадамж өсөхгүй	Өндөр
Мэргэжлийн шинжээчдын цалин, хангамж	Салбарын мэргэжлийн ажилчдын түвшинөөс доогуур	Ажиллах нөөц хангагдахгүй	Өндөр
Гадаад хамаарал	Тоног төхөөрөмж	Хугацаа алдах	Өндөр

4. Гол эрсдлүүд

1. Хууль эрх зүйн чадамж сул
2. Хүний нөөцийн хомсдол
3. Олон ослыг зэрэг шалгах чадамжгүй
4. Барилга, Техникийн хамаарал (FDR/CVR, лабораторигүй), өгөгдөл алдах эрсдэл
5. Сэтгэлзүйн ачаалал, ядаргаа
6. Санхүүгийн бие даасан чадамж сул

5. Эрсдэлийг бууруулах стратеги

5.1 Хүний нөөц

- Шинжлэн шалгагч, мэргэжилтнүүдийн нэмэлт орон тоо (хамгийн багадаа 15–18 болгох)
- Ур чадварын сургалтууд
- Олон улсын сургалт (ICAO стандарт)

5.2 Хууль эрх зүй

- Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 9 дүгээр бүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулах замаар өнөөгийн мөрдөж буй дүрэм, журмын зарим заалтуудыг хуулинд тусгаж оруулах
- Хуулийн дагуу байгууллагын дүрэм, журам, заавруудад нэмэлт, өөрчлөлт оруулах

5.3 Барилга байгууламж

- Тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалтын агуулахтай, ослоос үлдсэн овор ихтэй нотлох баримтуудыг байрлуулж шинжилгээ хийх боломжтой, лабораторийн цехтэйгээр албаны оффисийн барилгыг иж бүрэн шинээр барьж байгуулах.

5.4 Техник, тоног төхөөрөмж

- FDR/CVR унших тоног төхөөрөмжийг шинэчлэх, хөгжүүлэх
- Шинжлэн шалгалтын хөдөлгөөн хэрэгслээр хангах
- Хувийн хамгаалах хэрэгслээр иж бүрэн хангах
- Лабораторид шинжилгээ, судалгаа хийх боломжтой болгох
- Программ хангамжийг сайжруулах, кибер эрсдлээс хамгаалах

5.5 Үйл ажиллагаа

- Шуурхай хариу арга хэмжээ авах багийг байгуулах
- Ажил үүргийн хуваарийг 24/7 цагаар гаргах
- Гадаад хамтын ажиллагаа, харилцан туслалцааг хөгжүүлэх

5.6 Удирдлага

- Стандарт үйл ажиллагааны (SOP) хяналтын хуудсыг стандартчилах
- Чанарын баталгаа (QA), чанарын хяналт (QC) нэвтрүүлэх
- Шийдвэр гаргах, эрхийг шилжүүлэх системтэй байхыг дэмжих

5.7 Мэдээлэл

- Серверийн аюулгүй байдлыг хангах + Secure server + нөөц систем үүсгэх
- Өгөгдлийн шинжилгээний программ хангамж нэмэгдүүлэх
- Дижитал шинжилгээний нотлох баримтын менежмент

5.8 Санхүү

- Төсвийн нэмэгдэл, тодотгол хийх
- Шинжээчид, ажилчдын цалин хангамжийг салбарын ижил мэргэжлийн мэргэжилтнүүдийн түвшингээс дээш тогтоох
- Олон улсын төсөл, хамтын ажиллагааны түвшинд хүрэх зардлын эх үүсвэртэй байх

6. Ерөнхий дүгнэлт

Манай байгууллага нь:

- Жижиг бүтэцтэй ч маш өндөр хариуцлагатай
- Одоогийн байдлаар:

Суурь үйл ажиллагааг гүйцэтгэх чадамжтай боловч ачаалал даах чадамж хязгаарлагдмал, ачаалал нэмэгдэх үед эрсдэл өндөртэй.

- Хамгийн том асуудал:
- Хүчин чадал ба эрэлтийн зөрүү

7. Эцсийн үнэлгээ


- Нийт эрсдэлийн түвшин: **ӨНДӨР**

Нийт үнэлгээ:

- Маш өндөр эрсдэлтэй: 3
- Өндөр эрсдэлтэй: 18
- Дунд эрсдэлтэй: 4
- Бага эрсдэл: 0

Ерөнхий эрсдэлийн түвшин: ӨНДӨР

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН